

**ГХБХБГ-ЫН 05 ДУГААР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,  
СУДАЛГАА**

2019.05.02.

**ӨЛГИЙ СУМ**

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>“Газрын харилцааны ажилтны өдөр” 65 жилийн ойг тохиолдуулан Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохион байгуулж буй урлаг, спортын арга хэмжээнд манай байгууллагын мэргэжилтнүүд идэвхтэй оролцож байна.</p> <p>2019 оны 04 сарын 30-ны өдөр Төрийн ордны их танхимд Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Монголын геодези, фотограмметр, зурагзүйн холбоо хамтран зохион байгуулж буй "Геодези, зураг зүйн салбарын ажилтны II зөвлөгөөн"-д байгууллагын газрын даргатай геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн оролцов.</p> <p>3 барилгын компаниудаас ирүүлсэн тоосго, бетон шоо, газоблокны шинжилгээг хийсэн болно.</p> <p>Сумдын газрын даамлуудаас тогтмол 7 хоногийн мэдээ авч ажиллаж байна. <b>Тухайлбал:</b></p> <p><b>Алтай сум:</b> Сумын нутаг дэвсгэрт газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг газрын төлбөрийг хуулийн дагуу ногдуулж сумын төсөвт төвлөрүүлж байна.</p> <p>2 иргэний нэгж талбарын хувийн хэргийг ЛМ2 програмын цахимд архивласан. Мөн 2 иргэнд Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх захирамж гаргав.</p> <p><b>Алтанцөгц сум:</b> Улсын бүртгэлд 3 иргэний материал илгэж хоёр гэрчилгээнд “Г” дугаар авч гэрчилгээ олгон хувийн хэргийг ЛМ-д скайнерлэж оруулав. Мөн 04-р сарын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, 05-р сарын төлөвлөгөөг батлуулав.</p> <p><b>Бугат сум:</b> 9 иргэний үл хөдлөх материалын бүрдүүлж өгөв. 9 иргэний газрыг тэмдэглүүлж өгөв. Газрын төлбөрт 45000 төгрөг оруулав. 1 иргэнийг барьцаалагчийн бүртгэлд бүртгэв.</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 26-НИЙ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт
1	Аймагт зохион байгуулж буй сарын аян гэх зэрэг үйл ажиллагануудад идэвхтэй оролцох, ард иргэдэд шуурхай үйлчлэхийг үүрэг болгов.	7 хоног	Бүх байгууллагуудад	“Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ы хүрээнд ГХБХБГ-ын даргын удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд баригдаж байгаа барилгын угсралтын болон барилгын материалын үйлдвэрүүдэд талбайн орчны аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх үүднээс холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт хийж заавар зөвлөлгөө өгч ажилласан болно.